

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22
5.	ХАВСРАЛТ	23
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилтний асуудлын нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА
ЛАБОРАТОРИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Б.АМАР ТАНАА

2019.02.25 № 06/280
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн санхүүгийн тайланд

- Жил бүр давтагддаг тогтмол шинж чанартай үндсэн үйл ажиллагааны орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн бодитойгоор тооцож төлөвлөдөггүй. Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 152,955.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 844,818.5 мянган төгрөгөөр буюу 552.3 хувиар давуулж биелүүлсэн байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 182,554.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан.
- 2009-2011 онд үүссэн 58 хүнд хамаарах 23,543.8 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийн авлагыг барагдуулаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захирал Б.Амар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 11-нээс 2019 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Энич Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Энич Аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь Монгол Улсын хэмжээнд хүн амын эрүүл ахуй, аюулгүй орчинд амьдрах, чанартай хүнс, бараа бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд тавих төрийн хяналт шалгалтын ажлын үр дүнг бие даасан, хараат бус магадлан шинжилгээний дүнгээр баталгаажуулан хангаж, лабораторийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх

Үйл ажиллагааны чиглэл: Засгийн газрын 2013 оны 330 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ажиллах журам”-аар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх эрсдэлийн түвшинг үнэлэх
- Лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах
- Итгэмжлэгдсэн лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэг үзүүлэх, шинжилгээний дүнгийн нийцмэл байдлыг хангах
- Шинжилгээний дүнтэй холбоотой маргаан, хүсэлтийг хянах, баталгаажуулах, эцэслэн шийдвэрлэх арга хэмжээ авах, холбогдох төрийн захиргааны байгууллагад дүгнэлт, зөвлөмж гаргах

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хүнсний аюулгүй байдлын тухай хууль
- Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ажиллах журам”

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Емералд” програм хангамж ашигладаг байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг баталсан төсвийн дагуу хэрэгжүүлдэг төсвийн байгууллага тул материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгох нь зохимжтой гэж үзэв.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,047,468.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 100,949.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн, нөхцөл байдлыг харгалзаж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	4,021.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	4,200.5	
3	Албан шаардлага өгсөн	3	209,684.2	
	Дүн	6	217,906.3	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Шинжилгээний төлбөрийн мэдээ орлогын гүйлгээ, журналын дүнгээс 3,586.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, холбогдох нэгжүүдийн анхан шатны бүртгэл бүрэн бус, тооцооллын

алдаатай, орлогын дансны дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийг зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв ... бүртгэж, тайлагнах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2 дугаар зүйлийн "Орлогыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсэгт "Үйлчилгээний орлогыг холбогдох хууль тогтоомж заавар, гэрээнд заасан төлбөр ногдуулах журмын дагуу төлбөрийн хувь хэмжээ, төлөх хугацаа болон төлбөр хийсэн баримтыг үндэслэн бүртгэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.8.1.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 182,554.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан.

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлах бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 7.9-д "Хөрөнгийн зардал нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлтөөр тусгагдсан байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.8.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Нэр бүхий 5 ажилтанд 3,500.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон, мөн 2 ажилтанд цалингийн зөрүү хэлбэрээр 700.0 мянган төгрөгийн илүү цалин олгосон.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.8.1.4 Балансын данстай холбоотой асуудал

2009-2011 онд үүссэн, 58 хүнд хамаарах 23,543.8 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийн авлагыг барагдуулаагүй.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Жил бүр давтагддаг тогтмол шинж чанартай үндсэн үйл ажиллагааны орлогыг төсөвт хэт багаар тусгаснаас орлогын төлөвлөгөөг тайланд онд 552.3 хувиар давуулан биелүүлсэн байна. Иймд үйл ажиллагааны орлогыг дүн шинжилгээ, бодит тооцоололд үндэслэн төлөвлөх нь зүйтэй.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгиж шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 20 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,137,009.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,122,744.2 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

Тайлант онд өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 844,818.5 мянган төгрөгөөр буюу 552.3 хувиар давуулан биелүүлж, Сангийн сайдын 2018 оны 224 болон 275 дугаар тушаалаар үйл ажиллагааны давсан орлогоос 475,560.0 мянган төгрөгийг буцаан авч эх үүсвэр дутагдалтай байгаа урсгал зардлыг санхүүжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах, ажилтнуудын шагнал урамшуулал, нийгмийн асуудал шийдвэрлэхэд зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнд хамруулан Үндэсний аудитын газраас түүврийн аудит хийсэн ба тусгайлсан зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Ажилтнуудын гүйцэтгэж буй ажлын хэмжээ, цар хүрээ, үр дүнтэй уялдуулаагүй, албан тушаалын үндсэн цалинг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод жишгээс нэмэгдүүлэн тогтоож 3,416.8 мянган төгрөгийн цалин илүү олгосон.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна байгууллагын захиргаа болон ҮЭХ-ны хооронд 2017 оны 5 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан "Хамтын гэрээ"-ний 5.1-д "Ажил олгогч нь ажилтнуудын ажил, албан тушаалын үндсэн цалинг шинэчлэн тогтоохдоо Засгийн газраас баталсан төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод жишгээс нэмэгдүүлэн тогтоож шийдвэрлэнэ. Нэмэгдүүлж тогтоохдоо тэдний гүйцэтгэж буй ажлын хэмжээ, цар хүрээ, үр дүнтэй нь уялдуулна ..." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Төсвийг хэмнэлтгүй зарцуулах, зардал өсөх болон санхүүгийн үр дүн буурах

1.3 Өгсөн зөвлөмж:

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний холбогдох заалтыг хэрэгжүүлж, ажилтнуудын гүйцэтгэж буй ажлын хэмжээ, цар хүрээ, үр дүнг үнэлж, албан тушаалын үндсэн цалинг тогтоох

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Сахилгын шийтгэл оногдуулсан нэр бүхий 12 ажилтанд 604.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна ерөнхий захирлын 2016 оны А/03 тоот тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.10-т "Сахилгын шийтгэл хүчинтэй байх /1 жил хүртэл/ хугацаанд энэхүү журамд заасан шагнал, урамшууллыг олгохгүй бөгөөд ур чадварын нэмэгдлийг бууруулан олгоно..." гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Төсвийг хэмнэлтгүй зарцуулах, зардал өсөх болон санхүүгийн үр дүнг буруу тайлагнах

2.3 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж, сахилгын шийтгэл оногдуулсан ажилтнуудад шагнал, урамшуулал олгохгүй байх

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>316,945,653.86</u>	<u>677,390,518.42</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,000.00	10,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	10,000.00	10,000.00
31110	Төгрөг	10,000.00	10,000.00
33	АВЛАГА	24,570,850.72	30,809,425.02
335	Бусад авлага	24,570,850.72	30,809,425.02
3351	Байгууллагаас авах авлага	24,570,850.72	23,543,725.02
3352	Хувь хүмүүсээс авах авлага		7,265,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	292,364,803.14	516,581,093.40
351	Түүхий эд материал	76,435,548.16	178,983,491.13
35110	Тусгай зориулалттай материал	3,252,213.71	28,384,919.41
35130	Эм боох материал	73,183,334.45	150,598,571.72
354	Хангамжийн материал	215,197,855.13	336,466,202.42
35410	Бичиг хэргийн материал	13,840,195.85	20,859,877.85
35420	Аж ахуйн материал	9,116,778.66	15,027,932.74
35430	Сэлбэг хэрэгсэл	36,771,558.52	89,161,381.00
35470	Бусад хангамжийн материал	155,469,322.10	211,417,010.83
35600	Мал амьтад	731,399.85	1,131,399.85
36	НӨӨЦИЙН БАРАА	-	129,990,000.00
36700	Бусад санхүүгийн хөрөнгө		129,990,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,532,908,059.57</u>	<u>16,841,413,614.88</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,532,908,059.57	16,841,413,614.88
392	Биет хөрөнгө	18,396,908,059.57	16,568,801,977.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,073,519,068.00	12,104,050,304.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	824,115,678.57	1,004,083,684.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,436,620.00	108,436,620.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	93,633,848.53	96,627,209.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,488,738,157.87	13,626,100,217.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	7,046,631,515.24	8,733,587,067.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,294,906,852.69	1,326,521,352.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	650,560,744.89	807,424,940.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,000,000.00	50,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	3,750,851.76	4,583,613.86
393	Биет бус хөрөнгө	136,000,000.00	272,611,637.10
39301	Програм хангамж	137,046,000.00	137,046,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,046,000.00	18,034,362.90
39303	Бусад биет бус хөрөнгө		153,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>18,849,853,713.43</u>	<u>17,518,804,133.30</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,472,494.98</u>	<u>-</u>

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,472,494.98	-
413	Өглөг	2,472,494.98	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	819,065.00	
4136	Бусад өглөг	1,653,429.98	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,438,399.98	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	215,030.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>18,847,381,218.45</u>	<u>17,518,804,133.30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	18,847,381,218.45	17,518,804,133.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,406,900,816.70	2,560,500,816.70
512	Хуримтлагдсан үр дүн	16,419,991,421.24	14,882,727,910.07
51210	Өмнөх үеийн үр дүн	18,706,136,006.20	16,419,991,421.24
51220	Тайлант үеийн үр дүн	(2,286,144,584.96)	(1,537,263,511.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,488,980.51	75,575,406.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>18,849,853,713.43</u>	<u>17,518,804,133.30</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,880,843,991.31	3,510,204,766.00
110002	Үйл ажиллагааны орлого	1,224,373,891.31	1,013,380,653.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,224,433,891.31	1,013,380,653.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,224,433,891.31	1,013,380,653.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,224,373,891.31	1,013,380,653.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	841,022,382.20	1,002,598,373.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,921,520.00	8,322,280.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	377,429,989.11	2,460,000.00
120009	Бусад орлого	60,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,656,410,100.00	2,496,824,113.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,638,184,400.00	1,984,793,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,638,184,400.00	1,984,793,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,225,700.00	512,030,213.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		36,470,190.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,225,700.00	-
131106	Төсвийн урамшуулал		475,560,023.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,128,549,190.08	5,042,839,677.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,128,549,190.08	5,042,839,677.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,386,223,393.14	3,996,370,140.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,188,925,710.00	1,265,641,307.00
210101	Үндсэн цалин	1,065,718,910.00	982,219,907.00
210102	Нэмэгдэл		107,689,351.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,636,000.00	68,244,000.00
210104	Урамшуулал	42,570,800.00	20,721,049.00
210105	Гэрээт ажлын хөлс		86,767,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,098,890.00	142,094,600.00
210201	Тэтгэврийн даатгал	80,244,748.00	142,094,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,170,828.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,463,535.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	2,292,708.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	22,927,071.00	
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,504,911.24	114,382,249.00
210301	Гэрэл, цахилгаан	64,524,891.00	58,682,304.00
210302	Түлш, халаалт	28,244,526.00	31,664,813.00
210303	Цэвэр, бохир ус	8,063,882.24	8,095,520.00
210304	Байрны түрээс	8,671,612.00	15,939,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал	153,314,541.02	24,641,688.05
210401	Бичиг хэрэг	29,208,750.65	1,101,586.00

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	10,221,500.00	10,946,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,264,802.48	10,065,907.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,275,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,223,401.50	1,148,194.11
210408	Бараа материал акталсны зардал	104,121,086.39	
2105	Нормативт зардал	113,559,258.17	27,932,124.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,227,930.17	8,075,161.00
210502	Хоол, хүнс	18,331,328.00	19,856,963.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,268,400.00	25,144,518.00
210604	Урсгал засвар	9,268,400.00	25,144,518.00
2107	Томилолт, зочны зардал	1,032,000.00	2,853,400.00
210702	Дотоод албан томилолт	1,032,000.00	2,853,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,781,694.19	57,598,962.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,056,353.19	52,470,274.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	818,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,380.00	321,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,466,761.00	4,730,288.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,635,737,988.52	2,336,081,292.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,392,504.39	209,837,269.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,080,030.00	45,799,190.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,547,265,454.13	2,080,444,832.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	742,325,796.94	1,046,469,536.86
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	694,152,451.94	475,560,023.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	694,152,451.94	475,560,023.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,173,345.00	180,764,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,173,345.00	180,764,850.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	390,144,663.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		390,144,663.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-2,247,705,198.77</u>	<u>-1,532,634,911.26</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,439,386.19	4,628,599.91
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	38,439,386.19	4,628,599.91
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(38,439,386.19)	(4,628,599.91)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-2,286,144,584.96</u>	<u>-1,537,263,511.17</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,503,414,002.20</u>	<u>3,024,919,083.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	846,943,902.20	1,003,654,993.00
120	Нийтлэг татварын бус орлого	846,943,902.20	1,003,654,993.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	841,022,382.20	997,773,473.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	841,022,382.20	997,773,473.00
120005	Түрээсийн орлого	5,921,520.00	5,881,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,656,470,100.00	2,021,264,090.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,638,184,400.00	1,984,793,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,638,184,400.00	1,984,793,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,285,700.00	36,470,190.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		36,470,190.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,285,700.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,488,236,002.20</u>	<u>2,842,364,923.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,488,236,002.20	2,842,364,923.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,703,910,205.26	2,271,455,409.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,146,925,700.00	1,265,641,307.00
210101	Үндсэн цалин	1,065,718,900.00	982,219,907.00
210102	Нэмэгдэл		128,410,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,636,000.00	68,244,000.00
210104	Урамшуулал	570,800.00	
210105	Гэрээт ажлын хөлс		86,767,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,098,900.00	142,094,600.00
210201	Тэтгэврийн даатгал	80,244,758.00	142,094,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,170,828.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,463,535.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	2,292,708.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	22,927,071.00	
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,804,911.24	114,782,249.00
210301	Гэрэл, цахилгаан	64,524,891.00	58,682,304.00
210302	Түлш, халаалт	28,244,526.00	31,664,813.00
210303	Цэвэр, бохир ус	8,063,882.24	8,095,520.00

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210304	Байрны түрээс	8,971,612.00	16,339,612.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	38,865,798.08	53,499,356.94
210401	Бичиг хэрэг	13,391,796.00	19,538,688.00
210402	Тээвэр, шатахуун	10,221,500.00	10,946,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,224,177.08	10,065,907.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,275,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,753,325.00	11,568,761.00
2105	Нормативт зардал	205,775,850.00	379,980,994.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	184,784,522.00	353,687,031.00
210502	Хоол, хүнс	15,823,328.00	19,823,963.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,168,000.00	6,470,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,270,813.00	75,593,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,731,463.00	41,170,837.00
210602	Тавилга		4,375,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	511,000.00	5,999,230.00
210604	Урсгал засвар	9,028,350.00	24,047,683.00
2107	Томилолт, зочны зардал	1,032,000.00	2,853,400.00
210702	Дотоод албан томилолт	1,032,000.00	2,853,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,695,892.94	190,827,162.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,340,476.54	183,507,334.20
210803	Даатгалын үйлчилгээ	902,940.00	902,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,380.00	321,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,322,296.40	5,378,488.00
210807	Газрын төлбөр	1,689,800.00	640,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,440,340.00	46,183,090.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,060,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,380,340.00	46,183,090.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	784,325,796.94	570,909,513.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,173,345.00	180,764,850.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,222,569.00	6,030,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,950,776.00	28,734,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,000,000.00	146,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	694,152,451.94	390,144,663.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	694,152,451.94	390,144,663.86

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>15,178,000.00</u>	<u>182,554,160.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,178,000.00	182,554,160.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,178,000.00	182,554,160.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,178,000.00	182,554,160.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,178,000.00	182,554,160.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-15,178,000.00</u>	<u>-182,554,160.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,000.00	10,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,000.00	10,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,406,900,816.70	20,488,980.51	18,706,136,006.20	21,133,525,803.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,406,900,816.70	20,488,980.51	18,706,136,006.20	21,133,525,803.41
C07	Тайлант үеийн үр дүн			-2,286,144,584.96	-2,286,144,584.96
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,406,900,816.70	20,488,980.51	16,419,991,421.24	18,847,381,218.45
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,406,900,816.70	20,488,980.51	16,419,991,421.24	18,847,381,218.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,406,900,816.70	20,488,980.51	16,419,991,421.24	18,847,381,218.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		57,101,469.07		57,101,469.07
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	153,600,000.00	-2,015,043.05		-2,015,043.05
D06	Үндсэн хөрөнгийн нэмэгдэл				153,600,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			-1,537,263,511.17	-1,537,263,511.17
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,560,500,816.70	75,575,406.53	14,882,727,910.07	17,518,804,133.30

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,137,009,900.00	2,122,744,206.14	-14,265,693.86	99.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,137,009,900.00	2,122,744,206.14	-14,265,693.86	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,102,244,200.00	2,087,979,356.14	-14,264,843.86	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,184,122,800.00	1,184,081,284.00	-41,516.00	100.0
210101	Үндсэн цалин	900,701,400.00	900,659,884.00	-41,516.00	100.0
210102	Нэмэгдэл	128,410,400.00	128,410,400.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,244,000.00	68,244,000.00	-	100.0
210104	Урамшуулал	86,767,000.00	86,767,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,094,600.00	142,094,600.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	142,094,600.00	142,094,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,795,500.00	114,782,249.00	-13,251.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	39,369,500.00	58,682,304.00	19,312,804.00	149.1
210302	Түлш, халаалт	32,888,300.00	31,664,813.00	-1,223,487.00	96.3
210303	Цэвэр, бохир ус	30,075,100.00	8,095,520.00	-21,979,580.00	26.9
210304	Байрны түрээс	12,462,600.00	16,339,612.00	3,877,012.00	131.1
2104	Хангамж, бараа материалын зардал	53,500,100.00	53,499,356.94	-743.06	100.0
210401	Бичиг хэрэг	11,481,400.00	19,538,688.00	8,057,288.00	170.2
210402	Тээвэр, шатахуун	15,942,200.00	10,946,000.00	-4,996,200.00	68.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,948,400.00	10,065,907.94	-5,882,492.06	63.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	935,000.00	1,380,000.00	445,000.00	147.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,193,100.00	11,568,761.00	2,375,661.00	125.8
2105	Нормативт зардал	350,230,500.00	349,980,994.00	-249,506.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	323,830,000.00	323,687,031.00	-142,969.00	100.0
210502	Хоол, хүнс	24,070,500.00	19,823,963.00	-4,246,537.00	82.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,330,000.00	6,470,000.00	4,140,000.00	277.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,152,300.00	57,147,410.00	-4,890.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,916,800.00	27,100,497.00	-8,816,303.00	75.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,595,800.00	5,999,230.00	-5,596,570.00	51.7
210604	Урсгал засвар	9,639,700.00	24,047,683.00	14,407,983.00	249.5
2107	Томилот, зочны зардал	4,073,300.00	2,853,400.00	-1,219,900.00	70.1

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	4,073,300.00	2,853,400.00	-1,219,900.00	70.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,661,400.00	173,827,162.20	-8,834,237.80	95.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,113,400.00	166,507,334.20	-3,606,065.80	97.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00		-2,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,095,000.00	902,940.00	-2,192,060.00	29.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	695,000.00	321,400.00	-373,600.00	46.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	77,000.00	-11,000.00	87.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,530,000.00	5,378,488.00	-151,512.00	97.3
210807	Газрын төлбөр	640,000.00	640,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,613,700.00	9,712,900.00	-3,900,800.00	71.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,613,700.00	9,712,900.00	-3,900,800.00	71.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,765,700.00	34,764,850.00	-850.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,765,700.00	34,764,850.00	-850.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,030,600.00	6,030,600.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,735,100.00	28,734,250.00	(850.00)	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,030,600.00		-6,030,600.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,137,009,900.00	2,122,744,206.14	-14,265,713.86	99.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,984,054,900.00	1,119,089,213.14	864,965,686.86	56.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,984,054,900.00	1,119,089,213.14	864,965,686.86	56.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,955,000.00	1,003,654,993.00	850,699,973.00	656.2
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,955,000.00	997,773,473.00	844,818,473.00	652.3
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,881,520.00	5,881,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,000.00	10,000.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00	10,000.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	141	141		
620001	Удирдах ажилтан	4	4		
620002	Гүйцэтгэх ажилтан	109	109		
620003	Үйлчлэх ажилтан	10	10		
620004	Гэрээт ажилтан	18	18		

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	512,030,213.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	512,030,213.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	366,030,213.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	81,560,023.00
210101	Үндсэн цалин	-	81,560,023.00
2105	Нормативт зардал	-	30,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	30,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	201,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	170,000,000.00
210602	Тавилга	-	31,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	17,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	17,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	36,470,190.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	36,470,190.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	146,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	146,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	146,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	512,030,213.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	512,030,213.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	36,470,190.00
131106	Төсвийн урамшуулал	-	475,560,023.00

5. ХАВСРАЛТ

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилтний асуудлын нэгтгэл

Огноо: 2019/02/22	Аудитын нэр: Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/177/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	мянган төгрөгөөр:

№	Алдаа зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5			9	10
1	Шинжилгээний төлбөрийн мэдээ орлогын гүйлгээ, журналын дүнгээс зөрүүтэй, холбогдох нэгжүүдийн анхан шатны бүртгэл бүрэн бус, тооцооллын алдаатай, орлогын дансны дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийг зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй.	3,586.2	Албан шаардлага			Ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч	Б.Амар, Б.Эрдэнэчимэг
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдаж авсан.	182,554.2	Албан шаардлага			Ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч	Б.Амар, Б.Эрдэнэчимэг
3	2009-2011 онд үүссэн, 58 хүнд хамаарах 23,543.8 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийн авлагыг барагдуулаагүй.	23,543.8	Албан шаардлага өгөх			Ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч	Б.Амар, Б.Эрдэнэчимэг
4	Нэр бүхий 5 ажилтанд цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон, 2 ажилтанд цалингийн зөрүү хэлбэрээр илүү цалин олгосон.	4,200.5	Төлбөрийн акт			Ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч	Б.Амар, Б.Эрдэнэчимэг

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Ажилтнуудын гүйцэтгэж буй ажлын хэмжээ, цар хүрээ, үр дүнтэй уялдуулаагүй, албан тушаалын үндсэн цалинг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод жишгээс нэмэгдүүлэн тогтоосон.	3,416.8	Зөвлөмж			Ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч	Б.Амар, Б.Эрдэнэчимэг
6	Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнуудад урамшуулал олгосон.	604.8	Зөвлөмж			Ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч	Б.Амар, Б.Эрдэнэчимэг
	Нийт	217,906.3					

